



# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

20 22 он 03  
сарын 09 өдөр

Дугаар 35-1/75

Улаанбаатар  
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА  
ГОМБОЖАВЫН ЗАНДАНШАТАР  
ТАНАА

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тухай

Автотээврийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж өгөхийг хүсье.

Монгол Улсын Ерөнхий сайд



Л.ОЮУН-ЭРДЭНЭ

000224001598



МОНГОЛ УЛС  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20 <sup>᠒᠒</sup> он <sup>᠐ᠣ</sup> дугаар  
сарын <sup>᠒5</sup>-ны өдөр

Дугаар <sup>ХЭГ/᠑᠒</sup>

Улаанбаатар-12  
Утас: 260817  
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ЕРӨНХИЙ  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  
Л.ӨЛЗИЙСАЙХАН ТАНАА

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх  
хугацааг товлох тухай


Автотээврийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсэн тул холбогдох материалыг хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлож өгөхийг хүсье.

Хавсралт <sup>15</sup> хуудастай.

Монгол Улсын сайд,  
Засгийн газрын Хэрэг  
эрхлэх газрын дарга



  
Ц.НЯМДОРЖ


000225002459

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдааны 22 дугаар тэмдэглэлд:

“ХИ.ХЭЛЭЛЦСЭН нь: Автотээврийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Автотээврийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцээд, хуралдаан дээр Засгийн газрын гишүүдийн гаргасан саналыг тусган Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,  
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160

Утас/Факс: (976-51) 26 75 33,

Цахим шуудан: info@mojha.gov.mn,

Цахим хуудас: www.mojha.gov.mn

2022.04.19 № 1/2228

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ  
ГАЗРЫН ДАРГА Ц.НЯМДОРЖ ТАНАА**

Автотээврийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрөл өгөх нь зүйтэй гэж үзэв.



Х.НЯМБААТАР

**151601792**  
A5 Файл.2022



**МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,  
Утас/факс: (976-51) 26-74-68, <http://www.mof.gov.mn>

2022.04.19 № 01/2429

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН  
САЙД Х.НЯМБААТАР ТАНАА**

Автотээврийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрлийг үүгээр олгож байна.

Хүндэтгэсэн,



**Б.ЖАВХЛАН**

**9761000620**



## АВТОТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

### Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

#### 1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Их Хурлын 2021 оны “Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай” 106 дугаар тогтоолын 1.2-т “Хилийн боомтуудыг төмөр зам болон хатуу хучилттай авто замаар үе шаттайгаар бүрэн холбон, тээвэр, логистикийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэн ачаа тээврийн урсгалыг сайжруулж, цаашид транзит улс болох суурь нөхцөлийг бүрдүүлнэ” гэж, Монгол Улсын Их Хурлын 2020 оны “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай” 52 дугаар тогтоолын 5-д “Төрийн үйлчилгээг түргэн шуурхай, уян хатан, хүртээмжтэй, чанартай хүргэх хүний нөөцийн болон зохион байгуулалтын оновчтой арга хэрэгсэл нэвтэрч, иргэнд чиглэсэн төрийн үйлчилгээний чанар сайжирсан байна” гэж тус тус заасан.

Түүнчлэн Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” 47 дугаар захирамжид Хилийн Гашуунсухайт, Шивээхүрэн боомтын үйл ажиллагааг эрчимжүүлэхэд зайлшгүй шаардлагатай арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлэх үүрэг бүхий Ажлын хэсгийг Хууль зүй, дотоод хэргийн сайдаар ахлуулж ажиллахаар заасныг үндэслэн Автотээврийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

#### 1.2.Практик шаардлага

Монгол Улс болон БНХАУ-ын Засгийн газар хоорондын Автотээврийн хэлэлцээр болон түүнийг хэрэгжүүлэх протоколыг байгуулсан бөгөөд тус Хэлэлцээрийн 3.1-д “...хэлэлцэн тохирогч нэг талын машин хэлэлцэн тохирогч нөгөө талын нутаг дэвсгэрт нэвтрэхдээ хэлэлцэн тохирогч нөгөө талын эрх бүхий байгууллагаас олгох зорчих зөвшөөрөл, онцгой зөвшөөрөл авч нэвтэрнэ” гэж заасан бөгөөд зорчих зөвшөөрлийн бичгийг А, В, А-В, С, D, E, F гэсэн төрөл байхаар тус тус тусгасан.

Хэлэлцээрт С төрлийн зорчих зөвшөөрлийг байнгын ачаа тээвэр хийх тээврийн хэрэгсэлд олгох бөгөөд олгосон өдрөөс эхлэн 90 хоногийн дотор олон удаа хил нэвтрэхэд хүчинтэй байхаар заасан. Энэхүү төрлийн зорчих зөвшөөрлийн бичгийг уул уурхай экспортын тээвэр гүйцэтгэж байгаа тээврийн хэрэгслүүдэд олгож байна.

Протоколын 3.1-д “Зорчих зөвшөөрлийн бичгийг харилцан солилцох хэлбэрээр олгох бөгөөд хэлэлцэн тохирогч талуудын эрх бүхий байгууллагууд болон эрх олгогдсон байгууллагууд Хэлэлцээрийн 17 дугаар зүйлд заасан

уулзалтын үеэр дараа жилд хэрэглэх зорчих зөвшөөрлийн бичгийг харилцан адил зарчимд тулгуурлан тоог тогтоож, солилцох тодорхой хугацаа, газрыг хэлэлцэн тохирно” гэж заасны дагуу Монгол Улсын талаас “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ, БНХАУ-ын талаас Өвөр Монголын Өөртөө Засах Орон болон Шинжаан Уйгурын Өөртөө Засах Орны Зам, харилцаа тээврийн танхимууд жил бүр уулзалт зохион байгуулж, дараа жил ашиглагдах зорчих зөвшөөрлийн бичиг, онцгой зөвшөөрлийн бичгийн тоог тохиролцдог.

Цар тахлын онцгой нөхцөл байдлын улмаас болон БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах Орны Зам, харилцаа тээврийн танхимаас тус улстай хиллэдэг авто замын боомтуудаас Ганц модны боомтын хүчин чадлыг тооцож, Монголын талыг Гашуунсухайт-Ганцмодны боомтын чиглэлд 1 улиралд 6000-аас илүүгүй тээврийн хэрэгсэлд хил нэвтрэх С төрлийн зорчих зөвшөөрлийн бичиг олгох мэдэгдлийг удаа дараа ирүүлж байсан ба илүү олговол Ганцмодны боомтод мэдээлэл хүргэхгүй гэсэн шаардлага тавьдаг. Бусад боомтод тоо заагаагүй учир тээвэрлэлт гүйцэтгэх шаардлага хангасан тээвэрлэгч бүрд олгон ажиллаж байна.

Үүний дагуу “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-аас хил нэвтрэх зөвшөөрлийн бичиг олгох үйл ажиллагааг хөнгөвчлөх, мэдээллийн нэгдсэн сан үүсгэх, холбогдох хууль, дүрэм, журам, стандартаар хүлээсэн үүргийг хангасан тээвэрлэгчид хил нэвтрэх С төрлийн зорчих зөвшөөрлийн бичиг олгох зорилгоор Тээврийн нэгдсэн системийн програм хангамжийг 2019 онд нэвтрүүлсэн. Мөн зөвшөөрлийн бичгийг татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийн өргүй, автотээврийн байгууллагын стандарт, шаардлагыг хангасан байгууллагад олгож байна. Одоогийн байдлаар тус шаардлагыг хангасан 240 аж ахуйн нэгжийн 19062 тээврийн хэрэгсэл байна.

Иймд Гашуунсухайт боомтын чиглэлд улс хоорондын тээвэрлэлт эрхэлдэг 240 аж ахуйн нэгжийн 19062 тээврийн хэрэгсэлд С төрлийн зорчих зөвшөөрлийн 6000 бичгийг оновчтой хуваарилж олгох, зохицуулалт хийх шаардлага үүсээд байна.

“Эрдэнэс Тавантолгой” ХК, “Тавантолгой” ХК, “Энержи ресурс” ХХК зэрэг Тавантолгойн ордоос нүүрсний экспорт хийж байгаа компаниуд тээврийн үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжүүдтэй хариуцлагын гэрээг байгуулан ажиллахын зэрэгцээ нүүрс худалдах, худалдан авах гэрээ байгуулсан худалдан авагчийн нүүрс тээвэрлэгчдийн мэдээллийг баталгаажуулж, “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-т хүргүүлж байсан.

Энэ хүрээнд болон бусад хууль тогтоомж, дүрэм, журамд заасны дагуу “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-аас хил нэвтрэх С төрлийн зорчих зөвшөөрлийн бичгийг тээвэрлэгч байгууллагуудад олгодог. Гэвч тээвэрлэгч байгууллагуудаас “Энержи ресурс” ХХК болон “Тавантолгой” ХК-ийн нүүрсийг тээвэрлэхээр тус уурхай эзэмшигчидтэй гэрээ байгуулан авсан зөвшөөрлийн бичгээр “Эрдэнэс тавантолгой” ХК-ийн нүүрсийг тээвэрлэх тохиолдлууд их байдгаас “бэлэн мөнгөний тээвэрлэлт” гэсэн нэр томьёо бий болж тээвэрлэлтийн хөлс хэт өндөр болоход нөлөөлсөн байна. Нөгөө талаас хил нэвтрэх С төрлийн зорчих зөвшөөрлийн бичгийг худалдан авагчийн нүүрсний хэмжээнд тохируулан олгож чадахгүй, Цагаанхад дахь Гаалийн хяналтын талбай дахь худалдан авагч нарын нүүрсийг ижил хувиар тээвэрлэж чадаагүй зэргээс үүдэлтэй зарим худалдан авагч нар нүүрсээ яаралтай татаж авах зорилгоор тээвэрлэгч байгууллагууд өндөр үнэ амлаж нүүрсээ зөөлгөх замаар үнийн өсөлтийг бий болгосон.

Гаалийн байгууллагын Гашуунсухайт боомтоор 2022 оны 4 дүгээр сарын 1-7-ны өдрүүдэд нэвтрүүлсэн тээврийн хэрэгсэл, барааны мэдээллээс харахад 200 тээврийн хэрэгслээр 13,546.15 тн зэсийн баяжмал, 1032 тээврийн хэрэгслээр 142,272.3 тн нүүрс экспортолсон байна. Дээрх долоо хоногийн мэдээнд хил нэвтрэх зөвшөөрлийн бичиггүй 1 тээврийн хэрэгсэл ("Ивээл сар транс" ХХК-ийн 1826ӨМЭ 2022.04.01-ний өдөр), хугацаа дууссан зөвшөөрлийн бичгээр экспорт гүйцэтгэсэн 1 тээврийн хэрэгсэл ("Туруун транзит" ХХК-ийн 3334УАУ 2022.04.04)-д тус тус нүүрс ачиж экспортолсон нь байгууллагууд уялдаагүй ажиллаж байгааг илтгэж байна.

Түүнчлэн тээвэрлэгчдийн зүгээс өгч байгаа мэдээллээр С төрлийн зорчих зөвшөөрлийн үнийг нэмэгдүүлж, дамлаж зарах асуудал байдаг байна. Өөрөөр хэлбэл, авлига, албан тушаалын гэмт хэрэг бий болох магадлалтай байна.

### **Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Хуулийн төсөл 1 зүйлтэй байх бөгөөд уурхайн экспортын төлөвлөгөө болон худалдан авагчийн худалдан авсан бүтээгдэхүүний тоо хэмжээ, бүтээгдэхүүн зөөвөрлөх хугацаа, хил нэвтэрсэн гүйцэтгэл зэрэгтэй зайлшгүй уялдуулж зорчих зөвшөөрлийг олгох, хяналт тавих асуудлыг Засгийн газар шийдвэрлэх зохицуулалтыг тусгана.

### **Гурав.Хууль батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал**

Хуулийн төсөл батлагдсанаар уул уурхайн чиглэлээр улс хоорондын тээвэрлэлтийн зөвшөөрөл олгох төрийн үйл ажиллагаа ил тод, шударга, нээлттэй болох, бизнес эрхлэгчдэд үүсээд байгаа хүндрэл чирэгдлийг багасгах, бизнесийн шударга өрсөлдөөний зарчмыг хангах эерэг үр дагаврыг бий болгоно.

Түүнчлэн С төрлийн зорчих зөвшөөрлийг авах шаардлага хангасан тээвэрлэгчдийн мэдээллийг уурхай эрхлэгчдэд хүргүүлснээр өөрсдийн экспортын бүтээгдэхүүний хувь хэмжээтэй уялдуулж эдгээр тээврийн хэрэгслээс сонгож, шийдвэрлэх боломжийг бий болгосноор авлига, албан тушаалын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нөхцөл бүрдэнэ.

### **Дөрөв.Хууль тогтоомжийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал**

Автотээврийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн, Монгол Улсын олон улсын гэрээ, конвенц, бусад хууль тогтоомжтой уялдуулан боловсруулна.

## ТАНИЛЦУУЛГА

Автотээврийн тухай хуульд  
нэмэлт оруулах тухай хуулийн  
төслийн талаар

Монгол Улсын Их Хурлын 2021 оны “Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай” 106 дугаар тогтоолын 1.2-т “Хилийн боомтуудыг төмөр зам болон хатуу хучилттай авто замаар үе шаттайгаар бүрэн холбон, тээвэр, логистикийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэн ачаа тээврийн урсгалыг сайжруулж, цаашид транзит улс болох суурь нөхцөлийг бүрдүүлнэ” гэж, Монгол Улсын Их Хурлын 2020 оны “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай” 52 дугаар тогтоолын 5-д “Төрийн үйлчилгээг түргэн шуурхай, уян хатан, хүртээмжтэй, чанартай хүргэх хүний нөөцийн болон зохион байгуулалтын оновчтой арга хэрэгсэл нэвтэрч, иргэнд чиглэсэн төрийн үйлчилгээний чанар сайжирсан байна” гэж заасныг үндэслэн Автотээврийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Монгол Улс болон БНХАУ-ын Засгийн газар хоорондын Автотээврийн хэлэлцээрийг 2011 онд байгуулсан бөгөөд тус хэлэлцээрийн 3.1-д “...хэлэлцэн тохирогч нэг талын машин хэлэлцэн тохирогч нөгөө талын нутаг дэвсгэрт нэвтрэхдээ хэлэлцэн тохирогч нөгөө талын эрх бүхий байгууллагаас олгох зорчих зөвшөөрөл, онцгой зөвшөөрөл авч нэвтэрнэ” гэж заасан.

Энэхүү хэлэлцээрийн хүрээнд БНХАУ-ын талаас Монгол Улсад хүлээлгэн өгсөн зорчих болон онцгой зөвшөөрлийн бичгийг БНХАУ-ын нутаг дэвсгэрт нэвтрэх Монгол Улсын дугаартай тээврийн хэрэгсэл тус бүрд “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-аас олгон ажиллаж байна.

Мөн Монгол Улс болон БНХАУ-ын Засгийн газар хоорондын Автотээврийн хэлэлцээрийг хэрэгжүүлэх Монгол Улсын Зам, тээврийн хөгжлийн яам, БНХАУ-ын Зам, тээврийн яам хоорондын протоколын 1 дүгээр зүйлд “... эрх бүхий байгууллага нь Зам, тээврийн хөгжлийн яам, эрх олгогдсон байгууллага нь “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ байна” гэж тус тус заасан.

Зам, тээврийн хөгжлийн яам зөвшөөрлийн бичиг олгох ажлыг 2016 он хүртэл хариуцан ажиллаж байгаад Зам, тээврийн хөгжлийн сайдын 2016 оны 76 дугаар тушаалаар эрх олгогдсон байгууллага буюу “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-т шилжүүлсэн. Хэлэлцээрийг хэрэгжүүлэх яам хоорондын протоколын 2.2-т зорчих зөвшөөрлийн бичгийг А, В, А-В, С, D, E, F гэсэн төрөл байхаар тусгасан.

Протоколын 2.2-т “С төрлийн зорчих зөвшөөрлийг байнгын ачаа тээвэр хийх тээврийн хэрэгсэлд олгох бөгөөд олгосон өдрөөс эхлэн 90 хоногийн дотор олон удаа хил нэвтрэхэд хүчинтэй байна” гэж заасан. Энэхүү төрлийн зорчих зөвшөөрлийн бичгийг уул уурхай экспортын тээвэр гүйцэтгэж байгаа тээврийн хэрэгслүүдэд олгож байна. Мөн протоколын 3.1-д “Зорчих зөвшөөрлийн бичгийг харилцан солилцох хэлбэрээр олгох бөгөөд хэлэлцэн тохирогч талуудын эрх бүхий байгууллагууд болон эрх олгогдсон байгууллагууд Хэлэлцээрийн 17 дугаар зүйлд заасан уулзалтын үеэр дараа жилд хэрэглэх зорчих зөвшөөрлийн бичгийг харилцан адил зарчимд тулгуурлан тоог тогтоож, солилцох тодорхой хугацаа, газрыг хэлэлцэн тохирно” гэж заасан. Үүний дагуу Монгол Улсын талаас “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ, БНХАУ-ын талаас Өвөр Монголын Өөртөө Засах орон болон Шинжаан Уйгурын Өөртөө Засах Орны Зам, харилцаа тээврийн танхимууд жил бүр

уулзалт зохион байгуулж, дараа жил ашиглагдах зорчих зөвшөөрлийн бичиг, онцгой зөвшөөрлийн бичгийн тоог тохиролцдог.

Цар тахлын онцгой нөхцөл байдлын улмаас болон БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах Орны Зам, харилцаа тээврийн танхимаас тус улстай хиллэдэг авто замын боомтуудаас Ганц модны боомтын хүчин чадлыг тооцож, Монголын талыг Гашуунсухайт-Ганцмодны боомтын чиглэлд 1 улиралд 6000-аас илүүгүй тээврийн хэрэгсэлд хил нэвтрэх С төрлийн зорчих зөвшөөрлийн бичиг олгох мэдэгдлийг удаа дараа ирүүлж байсан ба илүү олговол Ганцмодны боомтод мэдээлэл хүргэхгүй гэсэн шаардлага тавьдаг. Бусад боомтод тоо заагаагүй учир тээвэрлэлт гүйцэтгэх шаардлага хангасан тээвэрлэгч бүрд олгон ажиллаж байна.

Үүний дагуу “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-аас хил нэвтрэх зөвшөөрлийн бичиг олгох үйл ажиллагааг хөнгөвчлөх, мэдээллийн нэгдсэн сан үүсгэх, холбогдох хууль, дүрэм, журам, стандартаар хүлээсэн үүргийг хангасан тээвэрлэгчид хил нэвтрэх С төрлийн зорчих зөвшөөрлийн бичиг олгох зорилгоор Тээврийн нэгдсэн системийн програм хангамжийг 2019 онд нэвтрүүлсэн. Мөн зөвшөөрлийн бичгийг татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийн өргүй, автотээврийн байгууллагын стандарт, шаардлагыг хангасан байгууллагад олгож байна. Одоогийн байдлаар тус шаардлагыг хангасан 240 аж ахуйн нэгжийн 19062 тээврийн хэрэгсэл байгаа бөгөөд С төрлийн зорчих зөвшөөрлийн 6000 бичгийг оновчтой хуваарилж олгох, зохицуулалт хийх шаардлага үүсээд байна.

Мөн Монгол Улсын уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2021 оны 01/494, 01/2211 тоот албан бичгүүдээр Гашуунсухайт-Ганцмод чиглэлд ашиглагдах хил нэвтрэх С төрлийн зорчих зөвшөөрлийн бичгийг “Эрдэнэс тавантолгой” ХК-д 60%, “Энержи ресурс” ХХК-д 25%, “Тавантолгой” ХК-д 15%-аар хуваарилан олгох саналуудыг ирүүлсэн. “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-аас уурхай эзэмшигч байгууллагуудын хүсэлтийн хүрээнд дээрх хуваарилалтыг баримтлан тээвэрлэгч байгууллагуудад олгодог. Гэвч тээвэрлэгч байгууллагуудаас “Энержи ресурс” ХХК болон “Тавантолгой” ХК-ийн нүүрсийг тээвэрлэхээр тус уурхай эзэмшигчидтэй гэрээ байгуулан авсан зөвшөөрлийн бичгээр “Эрдэнэс тавантолгой” ХК-ийн нүүрсийг тээвэрлэх тохиолдлууд их байдгаас бэлэн мөнгөний тээвэрлэлт гэсэн нэр томьёо бий болж тээвэрлэлт хэт өндөр үнэтэй болоход нөлөөлж байна. Нөгөө талаас худалдан авагчийн нүүрсний хэмжээнд тохируулан олгож чаддаггүйгээс Цагаанхад дахь Гаалийн хяналтын талбай дахь худалдан авагчийн нүүрсийг ижил хувиар тээвэрлэж чадаагүйгээс зарим худалдан авагч яаралтай нүүрсээ татаж авах зорилгоор тээвэрлэгч байгууллагуудад өндөр үнэ амалж нүүрсээ зөөлгөх замаар үнийн өсөлт бий болсон.

Гаалийн байгууллагын Гашуунсухайт боомтоор 2022 оны 4 дүгээр сарын 1-7-ны өдрүүдэд нэвтрүүлсэн тээврийн хэрэгсэл, барааны мэдээллээс харахад 200 тээврийн хэрэгслээр 13,546.15 тн зэсийн баяжмал, 1032 тээврийн хэрэгслээр 142,272.3 тн нүүрс экспортлсон байна. Дээрх долоо хоногийн мэдээнд хил нэвтрэх зөвшөөрлийн бичиггүй 1 тээврийн хэрэгсэл (“Ивээл сар транс” ХХК-ийн 1826ӨМЭ 2022.04.01-ний өдөр), хугацаа дууссан зөвшөөрлийн бичгээр экспорт гүйцэтгэсэн 1 тээврийн хэрэгсэл (“Туруун транзит” ХХК-ийн 3334УАУ 2022.04.04)-д тус тус нүүрс ачиж экспортлсон нь байгууллагууд уялдаагүй ажиллаж байгааг илтгэж байна.

Түүнчлэн тээвэрлэгчдийн зүгээс өгч байгаа мэдээллээр С төрлийн зорчих зөвшөөрлийн үнийг нэмэгдүүлж, дамлаж зарах асуудал байдаг байна. Өөрөөр хэлбэл, авлига, албан тушаалын гэмт хэрэг бий болох магадлалтай байна.

Иймд уул уурхайн чиглэлээр улс хоорондын тээвэрлэлтийн зөвшөөрөл олгох төрийн үйл ажиллагааг ил тод, шударга, нээлттэй болгох, бизнес эрхлэгчдэд үүсээд байгаа хүндрэл чирэгдлийг багасгах, бизнесийн шударга өрсөлдөөний зарчмыг хангах эерэг үр дагаврыг бий болгох зорилгоор Автотээврийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөлд ашигт малтмалын төлөвлөгөө болон худалдан авагчийн худалдан авсан бүтээгдэхүүний тоо хэмжээ, бүтээгдэхүүн зөөвөрлөх хугацаа, хил нэвтэрсэн гүйцэтгэл зэрэгтэй зайлшгүй уялдуулж зорчих зөвшөөрлийг олгох, хянах асуудлыг Засгийн газарт захиргааны хэм хэмжээний акт батлах эрх олгож зохицуулах байдлаар тусгалаа.

Хуулийн төсөл батлагдсанаар С төрлийн зорчих зөвшөөрлийг авах шаардлага хангасан тээвэрлэгчдийн мэдээллийг уурхай эрхлэгчдэд хүргүүлж өөрсдийн экспортын бүтээгдэхүүний хувь хэмжээтэй уялдуулан эдгээр тээврийн хэрэгслээс сонгон, шийдвэрлэх боломж бий болж авлига, албан тушаалын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нөхцөл бүрдэнэ.

Тус хуулийн төслийг олон улсын хөл хориот өвчин гарсан онцгой нөхцөлийг арилгах хүрээнд боловсруулсан тул Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.7-д заасны дагуу холбогдох үнэлгээ, судалгааг боловсруулах шаардлагагүй болно.

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2022 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**АВТОТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Автотээврийн тухай хуулийн 8 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 8.5, 8.6 дахь хэсэг нэмсүгэй:

“8.5.Улс хоорондын уул уурхайн байнгын ачаа тээвэрлэлт гүйцэтгэх тээврийн хэрэгсэлд зорчих зөвшөөрөл олгох, хяналт тавих журмыг олон улсын тээврийн харилцааны гэрээг үндэслэн Засгийн газар батална.

8.6.Энэ хуулийн 8.5-д заасан зөвшөөрлийг уул уурхайн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас нэгдсэн байдлаар уурхай бүрээр гаргасан экспортын бүтээгдэхүүний эзлэх хувь хэмжээнд нийцүүлэн олгоно.”

Гарын үсэг

АВТОТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН  
ТӨСӨЛД ЯАМДУУДААС ИРҮҮЛСЭН САНАЛЫН ТОВЧООН

№	Хаанаас	Саналын утга	Саналыг тусгасан байдал
1	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга 2022.04.13-ХЭГ/789	Автотээврийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлтэй танилцаад зарчмын хувьд дэмжиж байна. Хуулийн төсөлд тусгасан "...ул уурхайн болон санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас нэгдсэн байдлаар уурхай тус бүрээр гаргасан экспортын бүтээгдэхүүний эзлэх хувь хэмжээний хүрээнд..." гэсэн нөхцөлийг заавал хуульчлахгүйгээр батлан гаргах журамдаа тодорхой зааж оруулах нь зүйтэй.	Төслийг дэмжсэн. Уурхайн компанийн үйл ажиллагаатай уялдуулан тээврийн хэрэгсэлийн квотыг шударга зарчмаар тогтоох боломжийг бий болгох зорилгоор тус агуулгыг тусгасан.
2	Монгол Улсын Шадар сайд 2022.04.12-ЗГ-2/187	Автотээврийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон бусад холбогдох материалтай танилцлаа. Төсөлд тусгайлан өгөх саналгүй болно.	Тусгайлан өгөх саналгүй
3	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд 2022.04.14-01/1982	Автотээврийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон бусад холбогдох материалтай танилцлаа. Хуулийн төсөлд тусгайлан өгөх саналгүй болно.	Тусгайлан өгөх саналгүй
4	Батлан хамгаалахын сайд 2022.04.19-1а/1469	Автотээврийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцлаа. Хууль санаачлагчаас хуулийн төслийг боловсруулахдаа Хууль тогтоомжийн тухай хуулийн 15.4-т "Хууль тогтоомжоор зохицуулах нийгмийн харилцаа нь Засгийн газрын хэд хэдэн гишүүний эрхлэх асуудлын хүрээнд хамаарч байвал хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалын төслийг тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батална" гэж заасныг хангаагүй байх тул хуулийн төслийн үзэл баримтлалыг Автотээврийн болон Уул уурхай, хүнд үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүдтэй хамтран баталсны үндсэн дээр санал авах нь зүйтэй гэж үзэж байна.	Саналыг тусгаж, хуулийн төслийн үзэл баримтлалыг Автотээврийн болон Уул уурхай, хүнд үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүдтэй хамтран баталсан.
5	Гадаад харилцааны сайд 2022.04.13-09/1759	Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5.12-т заасны дагуу Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх хүрээнд авто тээврийн асуудал тусгагдсан тул Автотээврийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд дараах саналыг хүргүүлэв. Үүнд:	Саналыг агуулгын хувьд тусгасан

		1. "1 дүгээр зүйл. Автотээврийн тухай хуулийн 8 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 8.5 дахь хэсэг нэмсэггүй: "8.5. Улс хоорондын уул уурхайн байнгын ачаа тээвэрлэлт гүйцэтгэх тээврийн хэрэгсэлд зорчих зөвшөөрөл олгох, хяналт тавих журмыг холбогдох олон улсын гэрээг үндэслэн автотээвэр, уул уурхайн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас нэгдсэн байдлаар уурхай бүрээр гаргасан экспортын бүтээгдэхүүний эзлэх хувь хэмжээний хүрээнд Засгийн газар батална" зэрэг болно.	
6	Сангийн сайд 2022.04.12-01/2208	Таны санал авахаар ирүүлсэн Автотээврийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг дэмжиж Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасны дагуу Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх зөвшөөрлийг үүгээр олгож байна.	Төслийг дэмжсэн.
7	Барилга, хот байгуулалтын сайд 2022.04.14-1/1664	Хууль зүй, дотоод хэргийн яамнаас 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 1/2030 тоот албан бичгээр Автотээврийн тухай хуульд нэмэлт оруулах хуулийн төсөлд санал авахаар ирүүлсэн байна. Уг хуулиар зохицуулах харилцаа нь Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 12 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн 358 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Зам, тээврийн хөгжлийн яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрт заасны дагуу Зам, тээврийн хөгжлийн сайд болон тус яамны эрхлэх асуудалд хамаарч байна. Гэтэл Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Автотээврийн тухай хуульд нэмэлт оруулах хуулийн төслийн үзэл баримтлалыг баталж санал авахаар ирүүлсэн нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3-т "Засгийн газрын санаачлах хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалын төслийг тухайн асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулж, тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батална." гэж заасантай зөрчилдөж байгааг анхаарах саналтай байна.	Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны "Ажлын хэсэг байгуулах тухай" 47 дугаар захирамжид Хилийн Гашуунсухайт, Шивээхүрэн боомтын үйл ажиллагааг эрчимжүүлэхэд зайлшгүй шаардлагатай арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлэх хүрээнд тус хуулийн төслийг боловсруулсан.
8	Соёлын сайд 2022.04.15-1/989	Автотээврийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, танилцуулгатай танилцлаа. Тусгайлан өгөх саналгүй.	Тусгайлан өгөх саналгүй
9	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд 2022.04.011-01/965	Танаас ирүүлсэн Автотээврийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, хуулийн төслийн үзэл баримтлалын төсөлтэй танилцаад дараах саналтай байна. Хуулийн төслийн 8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсэгт "8.5 Улс хоорондын уул уурхайн байнгын ачаа тээвэрлэлтийн гүйцэтгэх тээврийн хэрэгсэлд уул уурхайн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас нэгдсэн байдлаар уурхай бүрээр гаргасан экспортын бүтээгдэхүүний эзлэх хувь хэмжээний хүрээнд зорчих зөвшөөрлийг	Уул уурхайн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас нэгдсэн байдлаар уурхай бүрээр гаргасан экспортын бүтээгдэхүүний хувь

		олгох, хяналт тавих журмыг олон улсын тээврийн харилцааны гэрээг үндэслэн Засгийн газар батална” гэж нэмснийг “8.5 Улс хоорондын уул уурхайн байнгын ачаа тээвэрлэлтийн тээврийн хэрэгслийн зорчих зөвшөөрлийг олгох , хяналт тавих журмыг зам, тээврийн болон уул уурхай, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар батална.” гэж өөрчлөн найруулах саналтай байна. Түүнчлэн хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг хавсралтын дагуу өөрчлөн найруулах саналтай байхын зэрэгцээ Сангийн сайдаар батлуулах нь зүйтэй гэж үзэж байна.	хэмжээний шаардлага тээврийн хэрэгслээс уул уурхай эрхлэгчид сонгох бөгөөд сонгосон тээврийн хэрэгсэлд С төрлийн зорчих зөвшөөрлийг олгохоор зохицуулалтыг тусгаж байгаа тул саналыг тусгах боломжгүй байна. Харин хуулийн төслийн үзэл баримтлалд саналыг тусгасан болно.	дагуу хангасан
10	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд 2022.04.13-01/995	Автотээврийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, үзэл баримтлал, танилцуулгатай танилцлаа. Тусгайлан өгөх саналгүй болно.	Тусгайлан өгөх саналгүй	
11	Эрчим хүчний сайд 2022.04.11-а/1429	Танаас ирүүлсэн Автотээврийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон холбогдох материалыг хүлээн авч танилцаад дараах саналыг хүргүүлж байна. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлд тусгасан 8.5 дахь заалтыг “Улс хоорондын уул уурхайн байнгын ачаа тээвэрлэлт гүйцэтгэх тээврийн хэрэгсэлд зорчих зөвшөөрөл олгох, хяналт тавих журмыг олон улсын тээврийн харилцааны гэрээг үндэслэн Засгийн газар батална” гэж өөрчлөн найруулж, 8.6 дахь заалтад “Энэ хуулийн 8.5-д заасан зөвшөөрлийг уул уурхайн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас хамтран гаргасан экспортын бүтээгдэхүүний эзлэх хувь хэмжээнд нийцүүлэн олгоно ” гэж нэмэх саналтай байна.	Саналыг тусгасан	
12	Цахим хөгжил, харилцаа холбооны сайд 2022.04.15-01/562	Танаас ирүүлсэн Автотээврийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлтэй танилцлаа. Тусгайлан өгөх саналгүй болно.	Тусгайлан өгөх саналгүй	

---000---

### Олон нийтээр хэлэлцүүлж буй хуулийн төсөл



АВТОТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ



ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

ҮНДЭГ ГҮЭЦЛЭГЖ БҮЙ АЛБАН  
ХААГЧДЫН ТООН МЭДЭЭ

f FACEBOOK

Хууль зүй, дотоод хэр  
55 likes

Like Page

TWITTER

Tweets by @moj\_mongolia

**ХЭДХЯ** @moj\_mongolia  
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРТГИЙН  
САЛБАРЫН АГЕНЛАГ,  
БАЛГУУЛАГАЙН ЧӨЗӨЛТӨЙ  
БӨДӨРЛӨГ ЗОХИОН БАЙ: ХУУЛГДЛАА  
mo.gov.mn/xevedkhya/7p-30

Embed

Sep 19, 2019

**ХЭДХЯ** @moj\_mongolia  
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРТГИЙН  
РААНЫ ТӨЛӨВӨГЧИД ХУУЛЬ ЗҮЙН  
ӨСӨРМӨЛ ОРЦУШСОО  
View on Twitter

**Автотээврийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах  
Ажлын хэсэгт ажиллах гишүүдийн нэрс**

№	Нэр	Албан тушаал	Утас	Цахим хаяг
1	П.Сайнзориг	Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга	266070	<a href="mailto:sainzorig@mojha.gov.mn">sainzorig@mojha.gov.mn</a>
2	Д.Цолмон	Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга	261957	<a href="mailto:tsolmon.d@mojha.gov.mn">tsolmon.d@mojha.gov.mn</a>
3	Б.Тэлмүүн	Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын Төсвийн орлогын хэлтсийн дарга	264193	<a href="mailto:telmuun_b@mof.gov.mn">telmuun_b@mof.gov.mn</a>
4	Ё.Жаргалсайхан	Зам, тээврийн хөгжлийн яамны Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга	99199648	<a href="mailto:jargalsaikhan@mrttd.gov.mn">jargalsaikhan@mrttd.gov.mn</a>
5	Р.Мягмаржав	Татварын ерөнхий газрын Орлогын газрын дарга	96008487	<a href="mailto:myagmarjav.r@mta.gov.mn">myagmarjav.r@mta.gov.mn</a>
6	Б.Гүрсоронзон	"Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын захирал	99116999	<a href="mailto:devshil88@gmail.com">devshil88@gmail.com</a>
7	М.Цолмон	Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын ахлах мэргэжилтэн	99072400	<a href="mailto:tsolmon.m@mojha.gov.mn">tsolmon.m@mojha.gov.mn</a>
8	Ч.Алтантуяа	Гаалийн ерөнхий газрын Гаалийн хяналт шалгалтын улсын байцаагч	99086321	<a href="mailto:altantuya628@customs.gov.mn">altantuya628@customs.gov.mn</a>